



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/405

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын 103 дугаар сургуулийн эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн ерөнхий боловсролын 103 дугаар сургуулийн эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 27,977,486.55 (хорин долоон сая есөн зуун далан долоон мянга дөрвөн зуун наян зургаан төгрөг тавин таван мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 103 дугаар сургууль (Ц.Оюунсайхан)-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 18 нэр төрлийн 27,977,486.55 (хорин долоон сая есөн зуун далан долоон мянга дөрвөн зуун наян зургаан төгрөг тавин таван мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 220,000.0 (хоёр зуун хорин мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 66,000.0 (жаран зургаан мянга) төгрөгийг нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Нийслэлийн ерөнхий боловсролын 103 дугаар сургууль (Ц.Оюунсайхан)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *В.Оюумаа* В.ОЮУМАА

1150501208

Нийслэлийн өмчийн
дартын 2024 оны
өдрийн ... дугаар

Байгууллага : Нийслэлийн Ерөнхий боловсролын 103 дугаар бүрэн дунд сургууль

Машин, тоног төхөөрөмж